



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/72

Төгөл

Сумын начин цол олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх заалт, Үндэсний Их Баяр наадмын тухай хуулийн 8 дүгээр зүйлийн 8.4, 9 дугаар зүйлийн 9.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын тулгар төр байгуулагдсаны 2233, Их монгол Улс байгуулагдсаны 818, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113, Ардын Хувьсгалын 103 жилийн ой, Хөвсгөл аймаг байгуулагдсаны 93 жилийн ой, Улаан-Уул сум үүсч хөгжсөний 93 жилийн ойн баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд аймаг, сумын цолтой 64 бөх барилдсанаас үзүүрлэсэн Чинбатын Сумъяабэйд "Сумын начин" цол олгосугай.

2. Ч.Сумъяабэйд сумын начны 2024/01 дугаар үнэмлэх олгохыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Батцогт)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сумын баяр наадмын төв комиссын дарга, Засаг даргын орлогч (М.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.



ДАРГА **Н.БАТБАЯР**

9072294 671511404

/Zahiramj/